

Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Шинжлэх ухааны доктор, профессор, Чингис хаан судлаач Дамбын Базаргүрийн намтар, шинжлэх ухаанд оруулсан хувь нэмэр (1932-2017)

Biography and contribution to science of Bazargur Damba (1932-2017), honorary member of Mongolian science, doctor of science, professor, and researcher on Chinggis khaan



Монгол улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор Д.Базаргүр

Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор Дамбын Базаргүр нь 1932 онд Хэнтий аймгийн Биндэр сумын нутагт сэрүүн галттай хэмээх газар Дамбын ууган хүү болон мэндэлжээ. Тэрээр 1941-1948 онд Биндэр сумын дунд сургууль, 1948-1950 онд Улаанбаатар хотын Багшийн сургууль, 1957-1961 онд Монгол Улсын Их сургуульд тус тус суралцан төгссөн. 1950-1957 онд Архангай аймгийн 10 жил, Өндөр-Улаан сумын дунд сургуульд багш, хичээлийн эрхлэгч, Цэцэрлэг хотын Багшийн сургуульд багш, 1961 оноос өнөөг хүртэл Шинжлэх Ухааны Академийн Газарзүйн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, тасаг, сектор, салбарын эрхлэгч, эрдмийн зөвлөлийн гишүүн, газарзүйн ухаанаар эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүн, төслийн удирдагч, зөвлөхөөр тасралтгүй ажилласан. 1962 оны 8 сард Байгалийн ухааны хүрээлэнд харьяалагдаж байсан Газарзүйн тасаг, Цэвдэг судлалын тасаг, Геологийн группийг нэгтгэн

байгуулсан Газарзүй, Цэвдэг судлалын хүрээлэнгийн анхны ажилтан бөгөөд Газарзүйн хүрээлэнгийн тулганы чулууг тавилцсан хүмүүсийн нэг. 1974 онд “БНМАУ-ын мал аж ахуйн хөгжил байршилтын газарзүйн үндэс” сэдвээр дэд эрдэмтэн, 1997 онд “Бэлчээрийн мал аж ахуйн газарзүй” сэдвээр газарзүйн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан бүтээлүүд нь газарзүйн шинжлэх ухаанд оруулсан онол аргазүйг хосолсон чухал бүтээлүүд болжээ. Монгол улсад зурагзүйн шинжлэх ухааныг улам хөгжүүлж сургалтын ба хэрэглээний зурагзүйн асуудлыг үндсэнд нь шийдвэрлэх болон карт атласыг анх удаа орчин үеийн зурагзүйн аргазүйн түвшинд зохиох, хэвлүүлэхэд хамт олноо удирдан зохион байгуулж ажилласан юм. Үүний үр дүнд 1962-1975 онуудад 8 атлас, 7 ханын карт зохион хэвлүүлснээр дунд сургууль, их дээд сургуулиудын газарзүйн бүх шатны сургалтад ашиглагдах болсноор ач холбогдолтой бүтээлүүд болсон юм. Монгол орныг үзэх, танилцахаар ирэх аялагч, ажил хэргийн хүмүүст зориулан замчлах, болон таниулах зураг картаар хангах нь зүйтэй гэсэн асуудлыг 1970 онд хөндөн тавьснаар жуулчдад зориулсан анхны карт, атласыг хэвлэн нийтлүүлж сурталчилснаар монгол оронд ирэх жуулчдын тоо өсжээ. “БНМАУ” жуулчдад зориулсан атлас, БНМАУ-ын жуулчдын зураг /масштаб 1:6 сая/ зохион БНАГУ-д хэвлүүлэн нийтийн хэрэгцээнд хүргэж байсан нь одоо түүхэн бүтээл болсон билээ. Монгол орны тусгаар тогтнолын баталгаа болсон улсын хилийг зурагжуулах, тэмдэгжүүлэх ажлыг БНХАУ-тай гүйцэтгэхэд оролцож, хоёр улсын хоорондох хилийг газар дээр нь тодотгон тогтоож зураглах (1960-1961) ажлын хэсэгт зурагзүйчээр ажиллажээ. Монгол орныг дэлхийд таниулан сурталчлах “БНМАУ-ын Үндэсний атлас” (1990) зохиох асуудлыг шийдвэрлэн хэвлүүлэхэд удирдан зохион байгуулах үүрэг гүйцэтгэсэнээс гадна мал аж ахуйн 20 гаруй зураг зохион оролцжээ. «БНМАУ-ын Үндэсний атлас» нь манай орны байгалийн нөхцөл, нөөц баялгийг судлан эзэмших талаарх шинжлэх ухааны мэдээллийн үр дүн, улс орны эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн түвшинг нэгтгэн дүгнэж зурагзүйн аргаар дүрслэн үзүүлсэн эрдэм шинжилгээ-лавлагааны суурь бүтээл юм. Уг атласыг тус улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх прогноз зохиох, аж ахуйг удирдан хөтлөх, байгалийн экологийн тэнцвэрийг хадгалах, хамгаалах баримтлал боловсруулах, түүнийг хөгжүүлэх арга хэмжээ авахад тулгуур зүйл болгон ашиглах боломжтой. Түүгээр ч барахгүй дэлхийн газарзүйн шинжлэх ухааны мэдээллийн санд зохих хувь нэмрээ оруулсан бүтээл болсны учир XX

зууны Монголын шинжлэх ухааны шилдэг бүтээлээр өргөмжлөгджээ. Монгол улс зурагзүйн хөгжлөөр “Үндэсний атлас” зохиох түвшинд хүрсэн өөрийн боловсон хүчинтэй, зурагзүйн шинжлэх ухааны өндөр чадавхтай болсноо дэлхийд харуулж чадсан юм. Газарзүйн шинжлэх ухаан Монгол оронд бэхжин хөгжих, судлахад өөрийн мэдлэг оюунаа зориулан ажилласан хугацаанд эрдэм шинжилгээний ажлын үр дүнгээсээ 18 нэгэн сэдэвт бүтээл, 16 атлас ба сэдэвчилсэн карт, 120 эрдэм шинжилгээний өгүүлэл, дангаар ба хамтран бичиж хэвлүүлэн, 482 газрын зураг хамтран зохиох, хянах ажил гүйцэтгэжээ. Монголын картографийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд өөрийн мэдлэг чадвараа зориулан олон карт, атлас зохион гаргажээ.



Онцлох зарим бүтээлүүд

Анх удаа Монголын бүх газар усны нэрийг байрзүйн зурагт тодотгож, нэрийн шинэчилсэн сан байгуулснаар “Газар усны нэр судлал”-ыг хөгжүүлэх суурийг тавьжээ. Мал аж ахуйн судалгааны чиглэлээр “Бэлчээрийн мал аж ахуйн газарзүй” гэсэн шинэ салбар ухааныг үүсгэн хөгжүүлж судалгааны ач холбогдол бүхий бүтээл туурвисан юм. 1986-1996 онуудад Өвөрхангай аймгийн Хужирт суманд нүүдэлчдийг суурьшуулах суурин туршилт судалгаа, Өвөрхангайн бүх сум, Дорноговь аймгийн Даланжаргалан сум, Ховд аймгийн бүх сумдад том масштабын зураглалын судалгаа явуулж, үүний үр дүнд малчдын соёл иргэншил бэлчээрийн мал аж ахуйн био экологи, байгалийн нөхцөл нөөц зэрэг 3 үндсэн хүчин зүйлийн харилцан уялдааг тогтоосон баялаг материал бүрдүүлэн түүндээ тулгуурлан Монгол малыг нутаг дэвсгэрт нь судлан байршуулж “Бэлчээрийн МАА-г” өсгөх зүй зохистой байлгах асуудлыг

шийдвэрлэсэн бол малыг даган амьдрах малчин өрхийн асуудлыг шийдвэрлэх талаар сүүлийн жилүүдэд судалгаа явуулж байна. “Бэлчээрийн мал аж ахуйн газарзүй” гэдэг бүтээл нь 1998 онд Монголын шинжлэх ухааны шилдэг бүтээлийн тэргүүн шагнал, 2002 онд ШУА-ийн эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн шагнал авсан. Тэрээр Монгол улсын нийгэм- эдийн засгийг тэнхлэгээр хөгжүүлэх үзэл баримтлал сэдвийн дагуу нэгэн сэдэвт зохиол 3, эрдэм шинжилгээний өгүүлэл 10-ийг нийтлүүлжээ. Монголын Нууц Товчоо судлалд үнэтэй хувь нэмэр оруулж, газарзүй, картографийн талаас нь судалж, “Чингис хаан” атлас зохиосон нь түүхэн газарзүйн судлалд чухал байр суурь эзэлж байна. Чингис хааны амьдралын түүхэн замналыг эцэг өвгөдийн үеэс Өгөөдэй хааны үеийг хамруулан харуулсан янз бүрийн масштаб бүхий газрын 26 зурагт багтаажээ. Нууц Товчоо бүтээлд өгүүлсэн үйл явдлыг газарзүйн үүднээс тайлбарлан үйл хөдлөл, газарзүйн нэрийн байршлыг нутаг дэвсгэртэй холбон судалж өгснөөр бодит ойлголтыг уншигч нарт болон судлаачдад өгч чадсанаараа “Чингис хаан атлас” онцлог юм.



Чингис хаан атлас, 2022 он

Тэрээр сүүлийн 20-иод жил Орос (1980-1990), Япон-Монголын хамтарсан төсөл (1990-1993), Канадын Монреал Их Сургуулийн Газарзүйн Департамент (1992-1995), БНСУ-ын Данкугийн Их сургууль, ХБНГУ-ын Берлиний Чөлөөт Их Сургуультай хамтарсан олон улсын эрдэм шинжилгээний төслүүдэд Монголын талаас удирдагчаар ажиллахын зэрэгцээ эдгээр төслүүдийн судалгааны ажилд өөрийн шавь нарыг удирдан оролцуулсан олон улсын нэртэй эрдэмтдийн нэг байсан юм. Дамбын Базаргүр эрдэм судлалын мөрөөр орж ажилласны 55 жилийн босгон дээр нь «Шинжлэх ухааны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж тус оронд сургалтын зурагзүйн асуудлыг шийдвэрлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан, газарзүйн шинжлэх ухаанд бэлчээрийн мал аж ахуйн газарзүй, түүхэн газарзүй шинэ салбар чиглэлийг үүсгэн хөгжүүлсэн, өөрийн шавь сургуулийг бий болгон олон эрдэмтэн сурган хүмүүжүүлсэн» ажлыг нь үнэлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015-2-17 өдрийн зарлигаар Монгол Улсын Шинжлэх Ухааны Гавьяат зүтгэлтэн цолоор шагнаснаар Газарзүйн Шинжлэх ухаанд нэгэн гавьяат нэмэгдсэн юм. Газарзүйн шинжлэх ухаанд оруулсан хувь нэмэр болон малчдын нүүдлийн судалгаагаар дэлхийд танигдсан олон улсын судлаачдын дунд нэр хүндтэй, дэлхийд зөвшөөрөгдсөн нүүдэл судлаач гэж үнэлдэг учраас энэ хүндэт цолыг хүртжээ. Тэрээр МУИС, УБИС-ийн газарзүйн ангиудад 20 гаруй жил мэргэжлийн хичээл заахын зэрэгцээ 10 гаруй аспирант горилогчийн эрдмийн ажлыг удирдан эрдмийн зэрэг хамгаалуулсан багш, удирдагч байсан юм. Профессор Д. Базаргүр дээрх судалгаа, бүтээл бүрд мэдлэг чадвар, удирдан зохион байгуулсны үр дүн шингэсэн бөгөөд монголын газарзүйн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд өөрийн хувь нэмэр оруулсан гавьяатан билээ.

Шинжлэх Ухааны Академийн Газарзүй, Геоэкологийн Хүрээлэнгийн 60/25 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Газарзүйн мэдээллийн систем, Зайнаас тандан судлалын салбар, Нийгэм, эдийн засгийн газарзүйн салбарууд хамтран Их эзэн Чингис хаан мэндэлсний 860 жилийн ой, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, Чингис хаан судлаач Дамбын Базаргүр агсны 90 насны ойтой холбогдуулан их эрдэмтний амьдрал, оюуны бүтээлийг оюутан залуус, эрдэм мэдлэг сонирхогч хүн бүхэнд таниулах арга хэмжээг 2022 оны 11 сарын 25-нд Чингис хаан музейн хурлын танхимд зохион байгуулав.

ШУА, Газарзүй, геоэкологийн хүрээлэн,

Газарзүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлалын салбар

2022.12.29